



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ.
2022 он**

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.06.28.

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 14 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт **63,5 хувь**, “**эрчимжүүлэх шаардлагатай**” гэж үнэллээ.

Бодлогын баримт бичигт тусгагдсан 68 арга хэмжээнээс 100%-тай 13; 90%-тай 8; 70%-тай 17; 50%-тай 15; 30%-тай 12; 0%-тай 3 арга хэмжээ байна.

“Алсын хараа -2050” хөгжлийн бодлогын хэрэгжилтийн түвшинг харуулбал:

Хүснэгт-1

№	Гэрээнд туссан арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн түвшин						Хэрэгжилтийн хувь
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Арга хэмжээ	68	13	8	17	15	12	3	63,5%

Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:

№	Бодлого															
	Нэг		Хоёр		Гурав		Гурав		Дөрөв		Тав		Зургаа		Ес	
	Үндэсний нагдамал үнэт зүйл	Гүйцэтгэл хувь	Хүний хөгжил	Гүйцэтгэл хувь	Амьдралын чанар ба дундаж давхарга	Гүйцэтгэл хувь	Амьдралын чанар ба дундаж давхарга	Гүйцэтгэл хувь	Дөрөв. Эдийн засаг	Гүйцэтгэл хувь	Засаглал	Гүйцэтгэл хувь	Ногоон хөгжил	Гүйцэтгэлийн хувь	Улаанбаатар ба дагуул хот	Гүйцэтгэлийн хувь
1	1.1.10	0	2.2.32	70	3.2.1	90	3.6.1	100	4.2.7	0	5.3.5	100	6.2.13	90	9.2.33	30
2			2.5.1	30	3.2.2	90	3.6.2	100	4.2.8	30	5.3.7	50	6.2.16	100	9.3.1	90
3			2.5.2	70	3.2.3	90	3.6.3	100	4.2.19	30	5.3.8	70	6.3.1	90	9.3.3	30
4			2.5.3	50	3.2.4	90	3.6.4	100			5.3.11	100	6.3.4	30	9.3.4	30

5		2.5.5	70	3.2.5	70	3.6.5	50			5.3.18	100	6.3.14	30	9.3.38	50
6		2.5.6	100	3.2.6	50	3.6.6	30					6.4.7	50	9.5.1	100
7		2.5.7	90	3.2.7	5	3.6.7	30					6.4.10	30	9.5.3	100
8		2.5.10	70	3.2.8	70	3.6.8	70					6.4.21	100		
9		2.5.11	70	3.2.9	70	3.6.9	50					6.4.22	50		
10		2.5.12	50	3.2.10	70	3.6.10	50					6.4.23	30		
11				3.2.11	70	3.6.11	70								
12				3.2.12	50	3.6.12	100								
13				3.2.13	70	3.6.13	70								
14				3.2.14	50	3.6.14	70								
15				3.2.15	50	3.6.15	0								
16						3.6.16	50								
17						3.6.17	70								

Тасарсан, 0%-тай арга хэмжээ 3 байна. Үүнд:

1.Арга хэмжээ 1.1.10. Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ хийж, дурсгалт газруудыг хамгаалж, газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгэнэ.

2.Арга хэмжээ 3.6.15. Геодезийн олон улсын маш урт суурь талтай интерферометрийн (VLBI) станц байгуулна.

3.Арга хэмжээ 4.2.7. Барилгын материал, мал, амьтны гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Хэрэгжилт хангалтугүй, 30 хувьтай арга хэмжээ 12 байна. Үүнд:

1.Арга хэмжээ 2.5.1. Орон сууцны нэг хүнд ногдох талбайн хэмжээг нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ.

2. Арга хэмжээ 3.6.6. Олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтцийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг хэрэглэгчдэд түгээх цахим тогтолцоог бий болгоно.

3. Арга хэмжээ 3.6.7. Монгол орны газар нутгийг бодит агшны мэдээлэл бүхий байр зүйн тоон зургаар зурагжуулж, хэрэглэгчдэд шуурхай хүргэж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангана.

4. Арга хэмжээ 4.2.8. Газрын гадаргын, үерийн болон борооны усыг хуримтлуулах, гол мөрний урсцад тохируулга хийх замаар аж үйлдвэрийн салбарын усны хэрэгцээг хангана.

5. Арга хэмжээ 4.2.19. Импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ.

6. Арга хэмжээ 6.3.4. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

7.Арга хэмжээ 6.3.14. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөн, шинээр барьж, шаардлага хангасан ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.

8.Арга хэмжээ 6.4.10. Барилгын салбарт ногоон, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ.

9. Арга хэмжээ 6.4.23. Цэвэрлэх байгууламж, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах туршилтын төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.

10. Арга хэмжээ 9.2.33. Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна.

11. Арга хэмжээ 9.3.3. Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

12. Арга хэмжээ 9.3.4. Олон төрлийн (орлогод нийцсэн, түрээсийн, ногоон) орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, 150,000 айлын орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хэрэгжилт хангалтгүй, 50 хувьтай арга хэмжээ 15 байна. Үүнд:

1. Арга хэмжээ 2.5.3. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

2. Арга хэмжээ 2.5.12. Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн бие даасан инженерийн хангамжид холбох, бичил дэд төвүүдийг байгуулах төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.

3. Арга хэмжээ 3.2.6. Орон сууцны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд татварын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тухайн орон сууцны тодорхой хувийг бага, дунд орлоготой иргэдэд түрээслүүлэх, хямд үнээр борлуулах замаар орлогод нийцсэн орон сууцаар хангана.

4. Арга хэмжээ 3.2.7. Зайлшгүй орон байраар хангагдах шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг төрийн өмчийн халамжийн түр орон сууцаар хангадаг тогтолцоог нэвтрүүлнэ.

5. Арга хэмжээ 3.2.12. Ногоон орон сууцыг нэвтрүүлэх бодлогын болон санхүүгийн дэмжлэгийн тогтвортой тогтолцоог бүрдүүлнэ.

6. Арга хэмжээ 3.2.14. Гэр хорооллын өрхийн газрыг өөрсдийн нь идэвх, санаачилга, оролцоонд тулгуурлан дахин зохион байгуулах, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, ногоон байгууламж, тоглоомын талбай бий болгох үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, улсын төсөв болон бусад хуулиар хориглоогүй эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг бий болгоно.

7. Арга хэмжээ 3.2.15. Орон сууцны төсөлд ухаалаг, байгалийн нөөцийн хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологи бүхий дэд бүтцийг улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаад, дотоодын зээл, тусламж, концессын гэрээгээр барьж байгуулах, нэвтрүүлэхийг банк, санхүүгийн тогтолцоогоор дэмжинэ.

8. Арга хэмжээ 3.6.5. Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн системийг бий болгоно.

9. Арга хэмжээ 3.6.9. Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.

10. Арга хэмжээ 3.6.10. Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.
11. Арга хэмжээ 3.6.16. Байрлалд суурилсан орон зайн мэдээллийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
12. Арга хэмжээ 5.3.7. Орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж шийдвэр гаргах бүх түвшинд ашиглана.
13. Арга хэмжээ 6.4.7. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлж, Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр (NDC) баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.
14. Арга хэмжээ 6.4.22. Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.
15. Арга хэмжээ 9.3.38. Улаанбаатар хотын “Төв цэвэрлэх байгууламж”-ийг шинэчлэн барьж ашиглалтад оруулна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт 2022 оны эхний хагас жилийн байдлаар **63.5** хувьтай, “**эрчимжүүлэх шаардлагатай**” гэж үнэлэв.

Тус яамнаас Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор; Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх “Чингис хаан” шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн 1000 га газарт Хөшигийн хөндийн Эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах асуудлыг УИХ-ын 2022.04.07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор; Төрийн захиргааны зарим байгууллагын ажиллах нэгдсэн байрыг Төв аймгийн Хөшигийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх асуудлыг Засгийн газрын 2022.03.09-ний өдрийн 98 дугаар тогтоолоор тус тус батлуулсан.

Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор баталсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тээвэр, ложистикийн төвийн ТЭЗҮндэслэл болон эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, ус хангамж, холбоо дохиолол, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулж, батлуулах ажлыг шуурхай зохион байгуулж ажилласны үр дүнд Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Шинэ Зуунмод” хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх боломж бүрдсэн байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Энэхүү урт хугацааны бодлогын баримт бичигт туссан боловч тасарсан 0%-тай дараах 3 арга хэмжээ болон хэрэгжилт хангалтгүй 30-50%-тай 27 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч ажиллахыг газрын дарга нарт даалгах; Үүнд:

-Геодезийн олон улсын маш урт суурь талтай интерферометрийн (VLBI) станц байгуулах,

-Барилгын материал, мал, амьтны гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх,

-Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ хийж, дурсгалт газруудыг хамгаалж, газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгэх.

2. Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүйн улмаас хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний санхүүжилтийг улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс шийдвэрлүүлэх боломжийг судлан шийдвэрлүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Э.Ганхүү/, Бодлого, төлөвлөлтийн газар /Б.Гүнболд/ болон холбогдох газрын дарга нарт үүрэг болгох;

3. Цаашид “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын жил бүрийн зорилтот түвшинг тодорхойлон батлах нь зүйтэй гэсэн саналтай байна.

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**